

БАЯЛАГ СҮМБЭР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 7-р сарын 1

№ ХЭХ-19/3

Улаанбаатар хот

Компанийн оноосон нэрийг өөрчлөх тухай

Баялаг сүмбэр ХК-ийн 2019 оны 7 сарын 1-ний өдрийн хувьцаа зэмшигчдийн ээлжит бус хурлын тоологын комиссын № ТК-19/2 тоот шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр “Глобал лайф технологи ХК”, Англи хэлээр “Global life Technology JSC” болгон өөрчилсүгэй.

ХОЁР. Компанийн оноосон нэрийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт зохих бүртгэлийг хийлгүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Хе Жинвен/-д даалгасугай.

ГУРАВ. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийг нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



/Б.ОТГОНБААТАР/

**БАЯЛАГ СҮМБЭР ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 7-р сарын 1

№ ХЭХ 19/4

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай

“Баялаг сүмбэр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 67-р зүйлийн 67.3.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зах хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.12 дах хэсэг болон 2019 оны 7 сарын 1-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын №ТК-19/2 тоот шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн шинэчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай;

ХОЁР. Компанийн шинэчилсэн дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст зохих бүртгэлийг хийлгүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Хе Жинвен/-д даалгасугай.

ГУРАВ. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБААТАР/

**БАЯЛАГ СҮМБЭР ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 7-р сарын 1

№ ХЭХ 19/5

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Баялаг сүмбэр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нь 2019 оны 7 сарын 1-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын №ТК-19/2 тоот шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай;

ХОЁР. Энэ тогтоолыг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



/Б.ОТГОНБААТАР/